

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/92/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: [ukhaanbilegm@audit.gov.mn](mailto:ukhaanbilegm@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СС	Сангийн сайдын
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Харлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.01.08 № 14  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
М.БАДАМСҮРЭН ТАНАА

Санхүүгийн тайланд аудит хийх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн шууд захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны эхэлж байна.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв толилуулсан эсэхэд аудит хийж, дүгнэлт гаргана.

Бид аудитыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, аргачлалын дагуу гүйцэтгэж аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажиллана. Санхүүгийн тайлангийн аудитаар:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлж, үнэлэх ба эдгээр эрсдэлтэй холбоотойгоор аудитын горимуудыг төлөвлөж, гүйцэтгэн аудитын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авна.
- Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болно.
- Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол, холбогдох тодруулгын үндэслэлтэй байдлыг үнэлнэ.
- Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх чадвартай холбоотой эргэлзээ төрүүлэх үйл явдал, нөхцөл байдалд хамаарах материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг дүгнэнэ.
- Тодруулгыг багтаасан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга болон ажил гүйлгээ, үйл явдлыг үнэн зөв тайлагнасан эсэхийг үнэлж дүгнэнэ.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж, судалгаа гаргана. Шилэн дансны тухай хууль болон бусад холбоотой хуулийн хэрэгжилтийг шалгаж, аудитын тайланд дүгнэлт оруулна.

011020857

Төсвийн захирагч нь дараах үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:

- Холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэж бодитой толилуулах.
- Залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналт хэрэгжүүлэх.
- Аудиторыг санхүүгийн тайлан бэлтгэхтэй хамаатай бүх мэдээлэлд нэвтрэх, нэмэлт мэдээллээр хангах, шаардлагатай ажилтнуудтай ямар нэгэн хязгаарлалт бэрхшээлгүй харилцах боломж олгох, ажиллах нөхцөлөөр хангах.
- Төрийн аудитын байгууллагын аудитортой харилцах, туслах үүргийг тодорхой ажилтанд хариуцуулах аудитын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх зэрэг үүрэг хариуцлага хамаарна.

Төрийн аудитын байгууллагын албан хаагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, дарамт шахалт үзүүлсэн тохиолдолд хууль бус үйлдлийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлж, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.
- Төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцыг хадгална.
- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил, аудиторын гаргасан шийдлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, аудитын тайлан болон дүгнэлтийг хүргүүлнэ.

Аудитыг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд харилцан хүлээсэн үүргээ биелүүлж хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Талуудын хүлээх үүрэг, хариуцлага болон бидний гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитын ажлын захидалтай танилцсан гэдгээ илэрхийлж хариу мэдэгдэнэ үү.

Хүндэтгэсэн;

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>969,060,182.47</b>	<b>2,785,533,099.97</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>921,429,582.47</b>	<b>2,785,533,099.97</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>921,429,582.47</b>	<b>2,785,533,099.97</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>921,429,582.47</b>	<b>2,785,533,099.97</b>
31211	Төрийн сангийн харилцах	921,429,582.47	2,785,533,099.97
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>47,630,600.00</b>	<b>0</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>47,630,600.00</b>	<b>0</b>
33510	Байгууллагаас авах авлага	47,630,600.00	0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>969,060,182.47</b>	<b>2,785,533,099.97</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>42100</b>	<b>Урт хугацаат үнэт цаас</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>969,060,182.47</b>	<b>2,785,533,099.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>969,060,182.47</b>	<b>2,785,533,099.97</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>969,060,182.47</b>	<b>2,785,533,099.97</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,755,268,786.47	969,060,182.47
51220	Тайлант үеийн үр дүн	-786,208,604.00	1,816,472,917.50
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>969,060,182.47</b>	<b>2,785,533,099.97</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>13,506,829,726.10</b>	<b>12,623,040,233.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,110,400,000.00</b>	<b>3,220,000,000.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,110,400,000.00</b>	<b>3,220,000,000.00</b>
122002	Хандив тусламж /гадаад/	3,110,400,000.00	3,220,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,396,429,726.10</b>	<b>9,403,040,233.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>10,396,429,726.10</b>	<b>9,403,040,233.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,227,735,385.10	0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	7,168,694,341.00	9,403,040,233.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	64,000,000.00	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>13,442,829,726.10</b>	<b>12,623,040,233.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,229,038,330.10</b>	<b>10,806,567,315.50</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	0	0
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	14,229,038,330.10	10,806,567,315.50
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-786,208,604.00</b>	<b>1,816,472,917.50</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>13,506,829,726.10</b>	<b>12,623,040,233.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,110,400,000.00</b>	<b>3,220,000,000.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,110,400,000.00</b>	<b>3,220,000,000.00</b>
122002	Хандив тусламж /гадаад/	3,110,400,000.00	3,220,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,396,429,726.10</b>	<b>9,403,040,233.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>10,396,429,726.10</b>	<b>9,403,040,233.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,227,735,385.10	0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	7,168,694,341.00	9,403,040,233.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>64,000,000.00</b>	<b>0</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	64,000,000.00	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>13,442,829,726.10</b>	<b>12,623,040,233.00</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>14,276,668,930.10</b>	<b>10,758,936,715.50</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,276,668,930.10</b>	<b>10,758,936,715.50</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>14,276,668,930.10</b>	<b>10,758,936,715.50</b>
223001	Бусад хөрөнгө	14,276,668,930.10	10,758,936,715.50
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-</b>	<b>-</b>
		<b>14,276,668,930.10</b>	<b>10,758,936,715.50</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-833,839,204.00</b>	<b>1,864,103,517.50</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,755,268,786.47	921,429,582.47
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	921,429,582.47	2,785,533,099.97

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>1</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1,755,268,786.47</b>	<b>1,755,268,786.47</b>
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1,755,268,786.47</b>	<b>1,755,268,786.47</b>
<b>9</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-786,208,604.00</b>	<b>-786,208,604.00</b>
<b>10</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>969,060,182.47</b>	<b>969,060,182.47</b>
<b>11</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>969,060,182.47</b>	<b>969,060,182.47</b>
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>969,060,182.47</b>	<b>969,060,182.47</b>
19	Тайлант үеийн үр дүн	0	0	1,816,472,917.50	1,816,472,917.50
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2,785,533,099.97</b>	<b>2,785,533,099.97</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,189,793,700.00</b>	<b>10,758,936,715.50</b>	<b>10,758,936,715.50</b>	<b>0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	0	0	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,189,793,700.00	10,758,936,715.50	10,758,936,715.50	0
223001	Бусад хөрөнгө	13,189,793,700.00	10,758,936,715.50	10,758,936,715.50	0
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13,189,793,700.00</b>	<b>12,623,040,233.00</b>	<b>12,623,040,233.00</b>	<b>0</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>9,923,742,400.00</b>	<b>9,403,040,233.00</b>	<b>9,403,040,233.00</b>	<b>0</b>
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	9,923,742,400.00	9,403,040,233.00	9,403,040,233.00	0
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>19,591,300.00</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	19,591,300.00	0	0	0
36	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>3,246,460,000.00</b>	<b>3,220,000,000.00</b>	<b>3,220,000,000.00</b>	<b>0</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,246,460,000.00	3,220,000,000.00	3,220,000,000.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	921,429,582.47	0	921,429,582.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	2,785,533,099.97	0	2,785,533,099.97

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 6/177 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 14,229.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 142.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн явцад дахин хянаж 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 10.806.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 108.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоох нь зохиомжтой гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлсэн эсэхийг тулган шалгасан. Үүнд тендер авч гэрээ байгуулж ажилласан гүйцэтгэгчийн мэдээллийг дутуу оруулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгахад дараах зөрчил илэрсэн.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн 2023 оны төсвийн төсөлд өгсөн саналд 2.3 тэрбум төгрөгийн 4 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хасах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх 1.8 тэрбум төгрөгийн 1 төсөл арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.

Үүнээс 1.9 тэрбум төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг хэвээр баталсан байна. Хүрэх үр дүнг бүрэн тодорхойлоогүй, төсвийн үр ашгийг сайжруулах шаардлагатай 1.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Дижитал аймаг төсөл”-ийг хасаж баталсан байна.

Ингэхдээ 2022, 2023 онд 4 удаагийн төсөвт өөрчлөлт оруулах тодотгол хийж Төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт аваагүй 5.2 тэрбум төгрөгийн 17 төсөл арга хэмжээг нэмж баталсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Зөвлөмж	1	47,630.60	1	47,630.60	100
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>47,630.60</b>	<b>1</b>	<b>47,630.60</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хэрэгжээгүй 9 төсөл, арга хэмжээний шалтгааныг тодруулах

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,899.2 сая төгрөгийн зөрчилд<sup>1</sup> хоёр зөвлөмж өгөв.

#### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим сайтад Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг сайтад оруулахдаа тендерт шалгарсан гүйцэтгэгчийн мэдээллийг бүрэн оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл." гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансанд орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг оруулахдаа тендерт шалгарсан гүйцэтгэгчийн мэдээллийг бүрэн оруулж ажиллах.

##### 2. Батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 74 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс 9 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй нь тендерт оролцогч ирээгүй, дараа он руу шилжүүлсэн зэрэг шалтгаантай хэрэгжээгүй нь төсөл, арга хэмжээний суурь судалгааг дутуу хийсэнтэй холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн "41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ". Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хангаж ажиллаагүй	1	1,899.21 3.4	-	-	-	-	1	1,899.213.4	-	-	-	-
Дүн	1	1,899.21 3.4	-	-	-	-	1	1,899.213.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тендерт шалгарсан этгээдийн мэдээллийг дутуу байршуулсан	1	0	-	-	-	-	1	0
Дүн	1	0	-	-	-	-	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-